



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/413

Эрдэнэт

**Хөрөнгө гаргах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4/в/, 29.2, Гамшгийн тухай хуулийн 4.1.1, 32.1.1, 32.1.3 дугаар заалт, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны IV хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Онцгой комиссын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн Баян-Өндөр сумын Эрдэнэ багийн нутаг дэвсгэрт үүссэн гамшгийн нөхцөл байдлыг арилгахад шаардагдах 43564905 /Дөчин гурван сая таван зуун жаран дөрвөн мянга есөн зуун таван/ төгрөгийг болзошгүй аваарийн зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

2.Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч /н.Батжаргал/-д даалгасугай.



Д.БАТЛУТ